

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 2 удаа хуралдлаа. Хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцлээ.

1. Хөнгөлөлттэй зээл олгох тухай
2. Төрийн дээд шагналд өргөн мэдүүлэх тухай
3. Хөрөнгө зарцуулах тухай
4. Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай хэлэлцэн шийдвэрлэлээ.

Бигэр сумын сум дундын эмнэлэг Монгол Улсын Хүний гавьяат эмч Л.Бордухын нэрэмжит болсонтой холбогдуулан Бигэр сумын сум дундын эмнэлэгт тогтоолыг гардуулан өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Төрийн дээд одон медалиар шагнагдсан хүмүүсийн шагналыг Халиун сумын 60 жилийн ойгоор гардуулан өглөө.

Аймгийн Засаг дарга тайлант сард бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 421 захирамж , гаргасан бөгөөд “Аймгийн сахилга хариуцлага дэг журмыг сайжруулах тухай”, “Төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах тухай” аймгийн Засаг даргын 2 албан даалгаврыг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар , сумдын Засаг даргын тамгын газарт албан бичгээр хүргүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 46 дугаар захирамж, Аймгийн Засаг даргын А/198 дугаар захирамжийн дагуу аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 13 дугаар хуралдаанаар Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн аймгийн урьдчилсан үзлэгийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудад 7 дугаар сарын 17-ны өдрөөс 26-ны өдрүүдэд, сумдад 9 дүгээр сарын 2-ны өдрөөс 7-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж явуулахаар шийдвэрлэсэн.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 51 байгууллагад 7 дугаар сарын 17-ны өдрөөс 26-ны өдрүүдэд үзлэгийг явуулж дүгнэхээр 6 ажлын хэсэгт 24 төрийн албан хаагч ажиллалаа. Ажлын хэсгүүд төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу үзлэгийг явуулж дүгнэн үнэлгээ өгч дүгнэхээс гадна зөрчил дутагдалтай, дутуу хийгдсэн зүйлүүдийг зөвлөн туслан биелэлтийг хангуулан ажиллалаа.

Говь-Алтай аймгийн Засаг даргын ивээл дор "Төрөлх нутгаа хамтдаа хөгжүүлэе" 1000 оюутан, залуусын урлаг, спортын их наадам 2019 оны 08 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд Алтай хотод зохион байгуулагдлаа. Энэ үеэр Урлаг, спортын их наадам, гар бөмбөг, үндэсний бөх, сур харваа, шатар теннис, ардын болон нийтийн дуу, эстрадын дуу, гоцлол бүжиг, уран уншлагын төрлүүдээр тэмцээн явагдаж, МАН-ын Ерөнхий Нарийн бичгийн дарга, "Төрөлх-Алтай" ТББ-ын тэргүүн Д.Амарбаясгалан, Улсын Их хурлын гишүүн Ш.Раднаасэд нар ивээн тэтгэж аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулж ажиллалаа.

Халиун сумын 60 жилийн ойн баяр наадам 08 дугаарын 3-5-ны өдрүүдэд “Алтайн хурд-2019 баяр наадам 08 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд тус тус зохион байгуулагдаж, аймгийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа.

БНХАУ-ын БНХАУ-ын Ганьсу мужийн даргын урилгаар УИХ-ын гишүүн Ш.Раднаасэд, аймгийн Засаг дарга В.Рэнцэндорж, Есөнбулаг сумын Засаг дарга бөгөөд Алтай хотын Ш.Дагва нар 2019 оны 07 дугаар сарын 31-ээс 08 дугаар сарын 01-ний өдрүүдэд Ганьсу мужид айлчлан “Торгоны Зам олон улсын соёлын үзэсгэлэн-IV, Дунхуань хотын Аялал-Торгоны Замын олон улсын Фестиваль-IX”-д оролцож, Зючиань хотын Сүбэй монгол үндэстний өөртөө засах хошууны удирдлагуудтай уулзаж хамтын ажиллагааг өргөтгөх талаар санал солилцлоо.

БНХАУ-ын Ганьсу муж болон тус аймгийн найрсаг харилцаа тогтоох санамж бичгийн дагуу ард иргэдийн найрамдалт, нөхөрсөг харилцааг бататган, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарт харилцан туршлага солилцох зорилгоор БНХАУ-ын Ганьсу мужийн Зючиань хотын Сүбэй Монгол Өөртөө Засах хошууны 15 малчдыг Монгол улсын үзэсгэлэнт байгалийг үзэж, малчдын ахуй амьдралтай танилцан туршлага судлах 11 хоногийн аялал 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Бургастай боомтоос эхэлж, Халиун сум байгуулагдсаны түүхт 60 жилийн ойн баяр наадамд оролцож, үндэсний сурын харваа, бөхийн барилдааныг үзэж сонирхлоо. Энэ үеэр Аймгийн Засаг дарга В.Рэнцэндорж Монгол нутгийг зорин ирсэн төлөөлөгч нарыг хүлээн авч уулзаж, хүндэтгэл үзүүлэн тэдний энэ удаагийн аялал нь хоёр талын ард иргэдийн аялал жуулчлалыг эхлүүлсэн ажил болж буйг дурьдан аялалд нь амжилт хүсэн ерөөлөө. Малчдын төлөөлөл Монгол орны үзэсгэлэнт байгаль, Улаанбаатар хотын хөгжил цэцэглэлттэй танилцан, Дорноговь аймгийн Замын-Үүдэд аялалаа өндөрлөлөө.

ОХУ-ын Новосибирск хотын дарга А.Е.Локотийн урилгаар “Олон улсын эдийн засаг, боловсролын “Азийн форум”-д 2019 оны 08 дугаар сарын 28-наас 30-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын боловсрол, соёл, урлаг хариуцсан мэргэжилтэн С.Цагаанбаатар, гадаад харилцаа хариусан мэргэжилтэн Э.Оюундарь нар оролцлоо. Уг форумын үеэр тус хотын Новосибирск хотын их сургууль, Физик, математикийн гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаатай танилцан, багш сурагчдыг туршлага солилцуулах талаар санал солилцон, Архитектур дизайн урлаг, Техникийн их сургууль, Новосибирскийн их сургууль, Анагаах ухааны их сургуулийн удирдлагуудтай уулзан, 2020-2021 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх, багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, туршлага судлах, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллахаар тохиролцлоо.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хууль зүй дотоод хэргийн яамнаас 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 1-4/3313 дугаар албан бичгийн дагуу Нотиратын үүрэг гүйцэтгэгчийн судалгаа ирүүлэх тухай хавсралт хүснэгтийн дагуу судалгааг гарган холбогдох газарт хүргүүлж ажиллалаа.

Хууль зүй дотоод хэргийн яаманд захиргааны ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн хэмжээг өөрчлөх тухай 4 журмын төслийг хянан үзэж, алдааг засч, хууль зүйн яаманд хүргүүлээд байна. Тайлант хугацаанд Жаргалан Дэлгэр Есөнбулаг, Баян-Уул, Хөхморьт, Эрдэнэ, Цээл, Халиун, Төгрөг сумдын Засаг даргын нийт 450 ш захирамжийг хянаж сум тус бүр дээр илэрсэн зөрчлийг арилгах, үг үсэг найруулагын алдаа, албан бичгийн стандарт зөрсөн, Хуулийг зүйл заалтыг буруу хэрэглэсэн зэрэг нийтлэг алдааг дахин гаргахгүй байх талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагаа явуулахад шаардлагатай байгаа тоног төхөөрөмж авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын А/272 дугаар захирамжаар 5 сая төгрөгийг шийдвэрлэлээ. Тус хөрөнгөөр 1 компьютер, 3 үйлдэлт принтер 1 ширхэг 1 үйлдэлт принтер 1 ширхэг өнгөт хэвлэгч 1 ширхэг нийт 4959600 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж авсан байна.

Аймгийн Засаг даргын ивээл дор “Засагт хан-2019” Баруун бүсийн буудлагын тэмцээнийг Холын буудлага, ойрын буудлагын 2 төрлөөр зохион байгуулж, аймгийн цагдаагийн газрын алба хаагчдыг хамгаалалтын бүсэд ажиллууллаа.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн хөтчийн ажиллах журмыг Хууль зүй дотоод хэргийн 2019 оны 08 дугаар сарын 02 өдрийн 1-3/3623 дугаар албан бичигтэй танилцаж, орон нутагт ажиллах эрх зүйн хөтчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хууль эрх зүйн хэлтсийн архивын тасаг иргэдийн хүсэлтийн дагуу 37 иргэнд мал тооллогын болон цалин, тушаалын лавлагаа олгон Төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тарифын дагуу 253000 төгрөгийн хураамжийг төрийн сангийн дансанд шилжүүлж иргэдэд үйлчиллээ. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, бусад төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагад төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн аймгийн урьдчилсан үзлэг явуулсан дүнг нэгтгэн гаргалаа.

Гаалийн хорооны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд заавар зөвлөгөө өгч ажиллалаа. 2019 оны 8-р сарын 14,15 өдрүүдэд сумдын Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн эрхлэгч нарт ERMS программын сургалт зохион байгууллаа. Аймгийн төвийн байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн үзлэг явуулсан дүнг нэгтгэлээ.

Чандмань, Алтай, Цогт, Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын архивын байнга хадгалах баримтын данс, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах хэргийн актыг хяналаа. Цогт сумын Давшилт нэгдлийн 1978-1980 оны 3074 хуудас баримт, Аймгийн Засаг даргын захирамжийн 9 хадгаламжийн нэгжийн 861 баримт, 2824 хүний нэр, 913 байгууллагын нэр, 853 газрын нэрийг шивж цахим холболт хийлээ. Аймгийн Засаг даргын захирамжийн 5 хадгаламжийн нэгжийн баримтаас 1110 хуудас баримтыг PDF файлд хөрвүүлээ. Аймгийн Засаг даргын 2019 оны 707 хуудас баримтыг сканердаж, Шарга сумын Говийн хөгжил нэгдэлийн 1974-1980 оны 1555 хуудас баримтыг photoshop программаар сэргээн засварллаа. 2019.08.05-09-ны өдрүүдэд сум байгууллагаас данс бүртгэл, байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах хэргийн акт, ХХНЖ-уудыг нягтлан шалгалт хийж байна.

Аймгийн Цагдаагийн газар Халиун сумын 60 жилийн ойн баяр наадам, “Алтай хурд-2019” баяр наадмыг зохион байгуулах хугацаанд нийгмийн хэв журам, замын хамгаалалтад холбогдох хууль хүчний байгууллагын алба хаагчдыг оролцуулсан.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн “Миний нутаг”, “Алтай, ТВ”, Цагдаагийн газрын Facebook, хуудсаар мэдээлэл, сэрэмжлүүлгийг байршуулж, Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудсанд байршуулсан видео шторкийг аймгийн олон дагагчтай группэд шэйрлэн түгээж мэдээг тухай бүр хүргүүлж ажиллалаа. “Яараад яахав дээ” аяны хүрээнд 2 төрлийн 200 ширхэг зөвлөмж гарган иргэдэд тарааж, сурталчиллаа.

Замын цагдаагийн тасаг тайлант хугацаанд давхардсан тоогоор 780 тээврийн хэрэгсэл шалгаж, 263 зөрчил илрүүлж 246 хүнд 9775000 төгрөгийн торгууль оногдууллаа. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 17 иргэнийг илрүүлж 12 иргэний жолоодох эрхийг 2 жилээр түдгэлзүүлж, 5 иргэнийг баривчлуулж, 17 тээврийн хэрэгслийг түр саатуулсан. “Орон нутгийн хөдөлгөөний соёл-2019” аяны хүрээнд 4 төрлийн гарын авлага боршур бэлтгэн иргэдэд сурталчилж ажиллалаа.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн төсвийн зарлага 2019 оны 08 сарын байдлаар 38563.2 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 35075.2 сая төгрөгийн буюу 90.9 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Үүнд: Орон нутгийн төсвийн зарлага 17670.7 сая төгрөгт хүрч, төлөвлөгдсөн зардал 85.1 хувийн, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага 3498,7 сая төгрөгт хүрч, төлөвлөгдсөн зардал 100 хувийн, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 97,8 сая төгрөгт хүрч, төлөвлөгдсөн зардал тус тус 100 хувийн гүйцэтгэлтэй байна

Орон нутгийн төсвөөс сумдад 6235.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудад 4562.1 сая төгрөгийн санхүүжилт, халамжийн санд 56.8 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус бүрэн олгоод байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Цогт сумын Ээж хөшөөнд дэмжлэг үзүүлэх тендерт оролцогч шалгараагүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Алтай суманд Спорт заалны барилга барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер үнэлгээний шатандаа байна.

Гамшгаас хамгаалах сангийн хөрөнгөөр Онцгой байдлын газарт шуурхай албаны автомашин нийлүүлэх барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцогч шалгараагүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Спорт заалын барилга /Говь-Алтай, Бугат сум/ барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер Үнэлгээний шатандаа байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Спорт заалын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцогч шалгараагүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Мал эмнэлгийн гэрчилгээний үндэсний систем нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер үнэлгээний шатандаа байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Жаргалан сумын төвлөрсөн халаалтын зуухны цахилгааны эх үүсвэрийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлалаа.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Биеийн тамир спортын газарт шаардлагатай техник, тоног төхөөрөмж нийлүүлэх барааны тендер "Альфа зууч" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Нэгдсэн эмнэлгийн гэмтлийн тасагт шаалдлагатай тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх барааны тендер "Голден мед" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Дөтийн давааны зам засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер "АЗЗА" ТӨХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Аймгийн төвийн хатуу хучилттай замын нөхөөс, засвар хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер "АЗЗА" ТӨХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Алтай хотын 70 жилийн цэцэрлэгт хүрээлэн"-д тохижилт хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт боллоо. Тендер үнэлгээний шатандаа байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх "Цахиур төмөр" түүхэн дурсгалын цогцолбор байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер "Онхотын булаг" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Хийдийн тохижилт-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер "Б.Алтаншагай ахлагчтай иргэдийн бүлэг" шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Аймгийн Засаг даргын Тамгын газрын засвар-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлалаа.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Спорт заалын барилга /Говь-Алтай, Бигэр сум/ барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер оролцогч шалгараагүй тул дахин зарлалаа.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Спорт заалын барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/ барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлалаа.

Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Найрамдлын хорооны 1.3 км сайжруулсан зам барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер үнэлгээний шатандаа байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлэгийн ажлын тендер үнэлгээний шатандаа байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Автозамын гэрлэн дохио, камер суурилуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер "Т.Ууганжаргал ахлагчтай иргэдийн бүлэг" шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Нэгдсэн эмнэлгийн "Аз жаргалын цэцэрлэгт хүрээлэн"-д тохижилт хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

ДӨРӨВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сарлаг үржүүлэгчдийн улсын зөвлөгөөн "Сарлагийн аж ахуйн үржүүлэг, технологи, үр дүн, цаашдын зорилт" сэдвээр 08 сарын 17, 18-ны өдрүүдэд Архангай аймагт зохион байгуулагдсан улсын зөвлөгөөн, сарлагийн баярт холбогдох мэргэжилтнүүд оролцлоо.

Энэ үеэр сарлагийн 10 гаруй төрлийн уралдаан тэмцээн, үзэсгэлэн худалдааны шалгаруулалт явагдлаа. Тус аймгийн Булган сумаас ирсэн сарлагийн үнээнээс нэг удаагийн саалтаар 3,1 л сүү гардаг нь онцлог байлаа.

Тус аймгийн Хөхморьт, Жаргалан, Тайшир, Эрдэнэ, Баян-Уул сумдад инженерийн хийцтэй худаг гаргах гэрээг "Сойл инжинеринг" ХХК-тай байгууллаа.

Аймгийн аюулгүй нөөцөд 2017, 2018 онуудад бэлтгэсэн өвс, тэжээлийн тооцоог гаргаж аймгийн Засаг даргын зөвлөлд танилцууллаа.

Үндэсний боловсруулах үйлдвэрт хонь, тэмээний ноос бэлтгэн тушаасан малчдын падаан холбогдох материалыг хүлээн авах, сумдын малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлж, тодорхойлсон талаарх мэдээллүүдийг нэгтгэх ажил хийгдэж байна.

Энэ онд нийт 17 сумын 2526 малчин, мал бүхий этгээдийн 512.3 тн хонины ноос, 68.7 тн тэмээний ноос нийт 581.04 тн ноосны баримт материалыг хуулийн хугацаанд хүлээн авч анхан шатны програмд орууллаа.

Монгол Улсын хэмжээнд малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлэх, тодорхойлох ажлыг зохион байгуулж байна. Дээрх ажлын хүрээнд Бугат, Чандмань сумууд малынхаа генетик нөөцийн төлөв байдлыг үнэлж, тодорхойлсон талаарх холбогдох материалаа хүлээлгэн өгөөд байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох журмын дагуу аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хорооны хуралдаанаар хэлэлцэн эрэмбэлж аймгийн Засаг даргын 2019 оны 07 сарын 24-ний өдрийн А/353 дугаар захирамжаар батламжилсан. Батламжлагдсан иргэн, аж ахуйн нэгжүүдтэй уулзаж, банк сонгосны дагуу ХААН, ХАС, Төрийн банкууд нэрсийг хүргүүллээ. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авахаар төсөл нь шалгарсан иргэн, аж ахуйн нэгжийн төслийг ХААН, Хас банкууд судалж эхлээд байна.

“Алтайн бахархал-2019” наадмын хурдан морины салбар комиссын бүрэлдэхүүнд тус газрын дарга, мэргэжилтнүүд ажиллаж амжилттай зохион байгуулсан байна.

Худалдааны байгууллагын 100 жилийн ойг угтаж Аймгийн Засаг даргын Тамгын газар, ИТХ-тай хамтран “Худалдаа-100” чуулга уулзалтыг 08 сарын 10-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Чуулга уулзалтад худалдааны байгууллагад ажиллаж байсан үе үеийн 500 гаруй төлөөлөгчид оролцлоо.

ХХААХҮ-ийн яаманд 7 хоног бүр арьс шир, түүхий эдийн үнийн судалгааг хүргүүлэн ажиллаж байна. Ноолуур 72,0 төгрөг, хонины үзүүрс 3,0 төгрөг, ямааны тарз 1,5 төгрөг байв.

Ургамал, түүний гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг хэвлэн баталгаажуулж сумдад хүргүүлсэн. Сумуудад хадлан хураалтын ажил явагдаж байна. Ургацын урьдчилсан балансыг гаргаж ХХААХҮ-ийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүллээ. Тайлант онд урьдчилсан байдлаар үр тариа 361 тн, төмс 723 тн, хүнсний ногоо 413 тн, жимс жимсгэнэ 200 тн, ногоон тэжээл 2160 тн хурааж авахаар тооцож байна.

Газар тариалан эрхлэгчдийн үзүүлэх сургалтыг 2019 оны 08 дугаар сарын 28-нд Халиун сумд зохион байгууллаа. Сургалтад 8 сумын 50 гаруй тариалан эрхлэгчид хамрагдаж Халиун сумын улсын аварга тариаланч Лхаажав, Алтанцэцэг нарын тариалангийн талбай болон жимсний аж ахуйн үйл ажиллагаатай танилцаж ил болон хамгаалалтай хөрсөнд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах агротехнологийн талаар зөвлөгөө өгч ажиллалаа.

Дэлхийн зөн ОУБ-тай хамтран үйлдвэрлэл эрхлэгчдийг туршлага судлуулах ажлыг Улаанбаатар хотод зохион байгуулахаар төлөвлөн ХХААХҮЯ-ны ШУОНТ-д албан бичиг хүргүүлж, удирдамж, хөтөлбөр боловсруулаад байна.

Мал эмнэлгийн газрын удирдамжийн дагуу Тайшир сумын саалийн хонь 486, ямаа 2796, үхэр 218, нийт-3500 хээлтэгч малыг бруцеллёзын сүүний цагирган урвалын шинжилгээнд хамруулсан. Шинжилгээгээр сэжигтэй болон эерэг урвалтай мал илрээгүй.

Жаргалан сумын “Гүнэ-Булаг” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирсэн хонины дээжинд бактериологийн шинжилгээ хийж, энтериобактериоз өвчин оношлогдож, тус сумд тухайн өвчинтэй тэмцэх заавар зөвлөмжийг хүргүүллээ.

Цогт сумын “Тайж-Чоно” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирсэн ямааны дээжинд бактериологийн шинжилгээ хийсэн. Шинжилгээнд энтериобактериоз өвчин оношлогдож, тус сумд тухайн өвчинтэй тэмцэх заавар зөвлөмжийг хүргүүллээ.

Жаргалан сумын “Бүрэн энэрэл” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирсэн хонины дээжинд бактериологийн шинжилгээ хийсэн. Шинжилгээгээр цусан халдварт өвчин илэрч, тус сумд тухайн өвчинтэй тэмцэх заавар зөвлөмжийг хүргүүллээ.

Халиун сумын “Буудайн хийморь” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирсэн ишигний дээжинд бактериологийн шинжилгээхийсэн. Шинжилгээгээр колибактериоз өвчин илэрч, тус сумд тухайн өвчинтэй тэмцэх заавар зөвлөмжийг хүргүүллээ.

Баян-Уул сумын “Үнэгт улаан” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирүүлсэн дээжнээс 39 дугаартай Батболдын 6 настай том хүрэн ухнаас бруцеллөз өвчний үүсгэгч илэрч тухайн сумын аж ахуй нэгжийн эмчид мэдэгдэн өвчний зааварчилгаа болон авах арга хэмжээг хүргүүлсэн.

Төвд үйл ажиллагаа явуулж байгаа 15 цайны газрын 1235 кг махны 13 дээж, 210 ширхэг өндөгний 2 дээжинд МЭАЦ-ийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олгосон.

ТАВ. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Газрын харилцааны чиглэлээр

Монгол улсын иргэнд газар өмчлөлийн тухай хуулийн дагуу хүсэлт ирүүлсэн 43 иргэний өргөдлийг хүлээн авч 2019 08 сарын 07-ны А/392 тоот захирамжаар өмчлүүлсэн. Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бямбадоржийн баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг 2019 оны 08 сарын 21-ноос 26-ны өдрүүдэд Халиун, Эрдэнэ, Чандмана, Дэлгэр сумдад ажиллаж, аймгийн Засаг даргын албадан чөлөөлүүлэх захирамж гарсантай холбогдуулан зөвшөөрөлгүй сунгасан, газар ашигласан хүмүүст мэдэгдэх хуудас хүргүүллээ.

Газар зохион байгуулалтын 09 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан төлөвлөгөөнд санал өгсөн боловч тухайн байршил, зориулалт нь батлагдаагүй тул энэ тухай иргэдэд мэдэгдээд байна. Мөн зөвшөөрөлгүй газраа сунгасан Иргэн Б.Гүррагчаа, Ё.Хатанбаатар, н.Алтай, н.Нэргүй нарт мэдэгдэх хуудас хүргүүллээ.

Есөнбулаг сумын Харзат багийн дундуур явсан авто замын трасст орсон 2 иргэний нөхөн олговорт 650,0 мянган төгрөг өгч газрыг нь чөлөөлүүлж явган хүний явах замыг тавих боломжтой болсон.

Сумын газрын даамлын үйл ажиллагаанд хяналт шалгалт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор 2019 оны 08 дугаар сарын 22-ноос 26-ны хооронд Баян-Уул сум, Жаргалан сум, Тайшир сумдад ажилласан.

Шинээр баригдах гэж буй төв цэнгэлэдэх хүрээлэнгийн газрын эргэлтийн 5 цэгийг газар дээр нь тэмдэгжүүлэн геологийн компанитай хамтран дээж авч жижүүр хөтлөлтийн мэдээллийн санд газар өмчлөлийн 28 иргэний хашааны газрын кадастрын зураглалыг орууллаа.

Геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийн сангийн загвар батлагдан үйл ажиллагаанд нэвтрүүлж байгаатай холбогдуулан ГЗБГЗЗГазартай хамтран Аймгийн хэмжээнд байгаа Үндсэн болон Дэд сүлжээний цэгүүдийн хувийн хэргийг мэдээллийн санд оруулж ажилласан.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт Газрын тухай хуулийг зөрчиж дур мэдэн зөвшөөрөлгүй хашаа хатгасан, газрын хэмжээг сунгасан зөрчил гаргасан иргэдэд холбогдох арга хэмжээ авахыг хүссэн албан бичиг хүргүүллээ.

Татварын цахим систем буюу e-tax.mta.mn системд хагас жилийн газрын төлбөрийн мэдээллийг шивж тайланг цаг хугацаанд нь илгээж, газрын кадастрын зураг 21 иргэнд, газар эзэмших эрхийн гэрчилгээ 15 иргэнд олгож, гэрээ байгууллаа.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр

Бигэр сумын 100 ортой сургуулийн дотуур байрны барилга, Есөнбулаг сумын Харзат багт 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Бигэр сум, 320 хүүхдийн сургуулийн барилга, Төгрөг сумын 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил, Есөнбулаг сумын 3.49 км хатуу хучилттай авто зам, явган зам дугуйн зам барих ажил, Дэлгэр сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил, Есөнбулаг сумын 5 км газарт 0,4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажил, Есөнбулаг сум, Усан бассейны барилга угсралтын ажил, Цээл сум, Алтайн хүдэр, "Мобиком Корпораци" ХХК-ийн Үүрэн телефоны GSM системийн станцын барилга, бичил долгионы 25 м өндөр төмөр цамхагийн барилга угсралтын ажил нийт 9 ажлын Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ гаргасан.

Дэлгэр сумын 320 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажил, 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил, Жаргалан сумын цэцэрлэгийн засварын ажил, Шарга сумын Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил, Есөнбулаг сумын усан бассейны барилга угсралтын ажил, Номын сангийн барилга угсралтын ажил, Мэргэжлийн хяналтын газрын барилга угсралтын ажил, Харзат багийн 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлуудад захилагчийн техник, хяналтын ажлыг 08 сарын 10-26-ны хооронд газар дээр нь хийсэн.

Алтай сумын цэцэрлэгийн барилга угсралтын ажилд шууд гэрээ байгуулах аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 3 компанид үнийн санал явуулан шалгаруулж гэрээ байгуулсан.

Мэргэжлийн хяналтын газрын барилга, Тайшир сумын сургуулийн дотуур байрны гэрээт хугацааг сунгах хүсэлтийг аймгийн ЗДТГ-т хүргүүллээ.

"Алтайн гэрэлт өргөө" ХХК, "Жи жи ай" ХХК -ийн тоосгонд лабораторийн шинжилгээ хийсэн.

Аймгийн Хөлбөмбөгийн холбооноос ирүүлсэн хөлбөгийн талбайд нэмэлт ажил хийлгэх хүсэлтийн хариуд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2019 оны 08 сарын 01-ний 318 дугаар албан бичгээр Алтай хотын Соёл амралтын хүрээлэнгийн хөлбөмбөгийн талбайн ажлын талаар тайлбар хүргүүлэв.

Сумдын төвд жишиг гудамж бий болгож тохижуулах ажлын Баян-Уул, Хөхморьт, Цогт, Шарга сумдын ажил гүйцэтгэх гэрээт хугацааг сунгах асуудлыг шийдвэрлэх тухай Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2019 оны 08 сарын 01-ний 317 дугаар албан бичгийг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүллээ.

Алтай хотод Дулааны станц барих ажлын хүрээнд төслийн багийнхан 08 сарын 19-нөөс 22-ний өдрүүдэд Алтай хотод ажиллах үеэр Алтай хотын 2 дугаар хэлхээний дулааны ачааллын тооцоог УДДТөв тус бүрээр тооцож ажлын хэсэгт хүлээлгэн өгөв.

Есөнбулаг сумын ЗДТГ-т хот доторх нийтийн тээврийн судалгааг хавсралт хүснэгтийн дагуу гарган ирүүлэх тухай Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2019 оны 08 сарын 14-ний 338 дугаар албан бичгийг хүргүүллээ.

Авто тээврийн газарт хот доторх нийтийн тээврийн судалгааг хавсралт хүснэгтийн дагуу гарган ирүүлэх тухай Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2019 оны 08 сарын 14-ний 336 дугаар албан бичгийг хүргүүллээ.

"Ди Ди Эй Жи" ХХК-д орон нутгийн судлах музейн барилгын трасст холбооны шугам давхцаагүй тухай Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2019 оны 08 сарын 08-ний 327 дугаар албан бичгийг хүргүүлэв.

Орон нутгийн өмчийн газарт Алтай хотын 3 замын уулзварт гэрлэн дохио хийх ажил, Соёл амралтын хүрээлэнгийн гэрэлтүүлэг, Гэрэл зургийн музейн архитектур төлөвлөлтийн даалгавар болосруулан хүргүүлэв.

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан боловсруулах ажлын хүрээнд цуглуулсан баримт материал, мэдээлэл бүрдүүлэхэд тулгамдаж буй асуудал болон Алтай хот доторх нийтийн тээврийн талаарх судалгааг холбогдох газруудаас авч нэгтгэн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2019 оны 08 сарын 15-ний 341 дугаар албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газарт хүргүүлэв.

Есөнбулаг сумын 2 дугаар хэлхээний дулааны шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлын даалгавар боловсруулав.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т сумдын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, усан бассейн зэрэг 15 барилгын зураг төсөл, газрын захирамж, техникийн нөхцөл зэрэг шаардлагатай материалуудыг бүрдүүлэн хүргүүлэв.

Дэд бүтцийн чиглэлээр

"Алтай-Улиастайн Эрчим хүчний систем" ТӨХК нь 2019-2020 оны өвлийн их ачааллын горимын техник тоног төхөөрөмжийн найдвартай байдлыг хангаж ажиллах бэлтгэл ажлуудыг хангаж ажиллан ЦДҮС, ББЭХС, Тайшир УЦС, Тосонцэнгэлийн УЦС, Улиастайн ДиЦС, Хүнгүй УЦС, Галуутай УЦС, Есөнбулаг ДиЦС сэргээгдэх эрчим хүч дизель генератор хосолсон нарны цахилгаан станц зэрэг эх үүсвэрүүдээр Говь-Алтай, Завхан аймгийн төвүүд болон 44

сум сууринг ЦЭХ-ээр тасралтгүй найдвартай ханган ажиллаж байна. Хоёр аймгийн хэмжээнд оргил ачаалал 9,5 МВт, бага ачаалал 4,5МВт. 2 аймгийн хоногийн хэрэглээ 160,000 мян.кВт.цагт хүрч ажиллав. Хоногийн нийт хэрэглээний 45%-ийг худалдан авалтаар, 55%-ийг дотоодын үйлдвэрлэлтээр ханган ажиллаа.

Оргил ачааллын үед Тайшир УЦС-3,0 МВт, Төвийн Бүсийн Нэгдсэн Сүлжээнээс 4,0МВт, Баруун бүсийн эрчим хүчний системээс 0,3МВт, Богдын голын УЦС 0,7 МВт, Тосонцэнгэл УЦС 0,2 МВт, нарны цахилгаан станцаар 0,3 МВт-ыг гарган ажиллаж байна.

“Ундарга-Алтай” ОНӨААТҮГ нь өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд 08-р сарын 30-ны өдөр урд чиглэлийн цэвэр усны салбар шугамуудад хаалт тавин ажиллалаа.

Алтай хотын ард иргэдийг аятай тухтай амьдруулах зорилгоор ажлын цагаар 70483656 дугаар, ажлын бус цагаар 99212073 дугаарын утсанд албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн цэвэр болон бохир усны яаралтай дуудлагын байнга хүлээн авч байна.

2019 оны 08-р сарын 30-ны өдрийн байдлаар

№	Дуудлагын төрөл	Албан байгууллага, ААН	Айл өрх	Нийт дуудлага	Дуудлага барагдуулалтын хувь
1	Цэвэр ус	8	30	38	90%
2	Бохир ус	12	37	49	100%
3	Гомдол	1	-	1	100%
Нийт		21	67	89	96,6%

Цэвэр усны шугам сүлжээ, тоног төхөөрөмжтэй холбоотой нийт 38 дуудлага ирсэнээс албан байгууллага-8, айл өрхөөс-30, бохир усны шугам сүлжээ, тоноглолтой холбоотой 49 дуудлага ирсэнээс албан газар 12, айл өрхөөс 37 дуудлага тус тус ирсэн байсан. Дээрхи хугацаанд гомдол, санал 1 ирсэнийг шийдвэрлэсэн байна. Дуудлага барагдуулалт 96,6%-тай байгаа бөгөөд 8 сарын 30-ны өдрийн байдлаар борлуулалтын орлого албан байгууллага 25863,3 сая төгрөг, орон сууц 17556,1 сая төгрөг, ус түгээх байр 118,9 мянга төгрөг, зөөврөөр 3215,4 сая төгрөг байна.

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Томуу, томуу төст өвчин эпидемиологийн 34 дүгээр долоо хоног буюу 08 сарын 27-ны байдлаар аймгийн хэмжээнд амбулаторийн нийт 1982 үзлэгээс 9 буюу 0.4%-ийг, яаралтай тусламжийн дуудлагын 207 үзлэгээс 12 буюу 5.7%-д томуу, томуу төст өвчин гэж оношлогдлоо.

“Нүүдлийн амбулатор”-ийн үзлэгийн 2 дахь ээлж хойд бүсийн сумдад үргэлжилж байна.

Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлтэй хамтран хэрэгжүүлж буй “Эрүүл Алтай” хөтөлбөрийн хүрээнд Аймгийн нэгдсэн эмнэлгийн дотор, хэт авиан оношилгоо, арьс харшил, бэлгийн замаар дамжих халдварын эмч нарын баг урд бүсийн 9 сумын алслагдсан багийн иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээг давхардсан тоогоор 1700 гаруй иргэнд хийж, эрүүл амьдралын зөв дадлын талаар 380 хүнд сургалт, сурталчилгаа зохион байгууллаа.

Бигэр сумын сум дундын эмнэлэгт Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 20.0 сая төгрөг батлан тендер зарлаж “Дес” ХХК” шалгарч аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2019 оны А/32 дугаар албан тоотойр томилогдсон ажлын хэсэг Бигэр сумын сум дундын эмнэлэгт шүдний 15.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаар санхүүжигдэх Нэгдсэн эмнэлгийн гэмтлийн тасагт тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг

“Голден мед” ХХК гэрээ байгуулах эрх олгох аймгийн Засаг даргын 2019 оны А/404 дугаар захирамжийн дагуу тус компанитай гэрээ байгууллаа.

ДЗМОУБ-ын Говь- Алтай ОНХ-ийн эх хүүхдийн эрүүл мэнд төслийн дэмжлэгтэйгээр Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хяналтыг чанаржуулах, шинэлэг санаа, санаачлага, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх арга зам, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг судлах зорилгоор Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвд 7 хоногийн хугацаатай Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн 1, Нэгдсэн эмнэлгийн эмнэлгийн тусламж хариуцсан дэд захирал 1, хүүхдийн зөвлөх эмч 1, хүүхдийн эмч 1, Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч 22 нийт 26 эмч, мэргэжилтэн ажлын байрны сургалт болон туршлага судлах сургалтанд хамрагдлаа.

Гэр бүл, хүүхэд залуучуудын газартай хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 1 сурагчид эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 3 цагийн сургалт зохион байгууллаа.

ДЗМОУБ-ын санхүүжилтээр сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан 16 хүнд, “Эрүүл мэндийг дэмжих өдрийн үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудал” сэдвээр сургалт, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сайн дурын идэвхтнүүд 110 хүнд уулзалт өртөөчилсөн сургалтыг тус тус зохион байгууллаа.

ДОЛОО. БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2019-2020 оны хичээлийн жилийн босгон дээр сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа, чанарын үнэлгээний судалгаа, Монголын багш нарын VII их хурлын төлөөлөгч багш нар болон багш нарын 3 удаагийн үндэсний хэлэлцүүлгийн дүгнэлтийг үндэслэн:

1.Сургалтын хөтөлбөрийн агуулгын давхардал, хүндрэлийг арилгаж хэрэгжих нөхцөл боломжийг нэмэгдүүлэх.

2.Суралцах үйл ажиллагааг сурагчийн үнэт зүйл, хандлага, төлөвшилд чиглүүлэх.

3.Сургалтын цөм хөтөлбөрийн дараагийн үе шатны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.

4.Сурагчдын сурах болон багшийн багшлах ажлын ачааллыг зохистой болгох.

Сургуулийн хичээлд суурилсан үйл ажиллагааны менежмент, төлөвлөлтийг дэмжиж, сургуулийн сургалтын хөтөлбөр, багшийн хичээл төлөвлөлтийг хөгжүүлэх зэрэг хэрэгцээ шаардлагыг хангах зорилготой “Сургалтын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх арга зүй” сэдэвт сургалтыг 2019 оны 08-р сарын 20-23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан, багш, арга зүйчид нийт 1025 хүн 19 чиглэлээр суралцлаа.

БСШУСЯ, АХБ-ны Баруун бүсийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төслийн хүрээнд “Дотуур байран дахь хичээлээс гадуурх үйл ажиллагаа, эцэг эхийн оролцоо” туршлага солилцох уулзалт семинар Говь-Алтай аймагт 2019 оны 25-26-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү уулзалтад Говь-Алтай аймгийн дотуур байрын багш нар, сургуулийн нийгмийн ажилтан, бага ангийн багш нараас гадна Баянхонгор, Говьсүмбэр, Өмнөговь, Дундговь, Ховд, Өвөрхангай аймгийн төлөөлөл нийт 250 гаруй төлөөлөгчид оролцон танхимын болон Шарга сумын дотуур байрны туршлагаа солилцов. Мөн НЛМ Норвегийн тусламжийн байгууллага, Японы хүүхдийг ивээх сан, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл зэрэг байгууллагуудын дотуур байранд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны туршлагыг хуваалцаж, асуудал бэрхшээлээ хэлэлцэн шийдвэрлэх арга замуудаа хамтран тодорхойлж БСШУЯ-нд хүргүүллээ.

Энэ хичээлийн жилийн багш нарын бага хурлыг “БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ШИНЭЧЛЭЛ” сэдвийн хүрээнд 2019 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Ардын дуу бүжгийн “Алтай” чуулгын хурлын танхимд зохион байгууллаа. Бага хуралд сургуулийн захирал, сургалтын менежер, заах аргын нэгдлийн ахлагч, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр 130 орчим төлөөлөгч оролцлоо. Хурлыг нээж Боловсрол, соёл урлагийн газрын дарга Р.Батмөнх үг хэлж 2018-2019 оны хичээлийн жилийн зорилтын биелэлт, цаашид анхаарах асуудлын талаар илтгэл тавилаа. Мөн Баян-Уул сумын сургуулийн захирал Д.Ганхуяг “Сургалтын чанарын шинэчлэл” сэдэвт илтгэл, Удирдлагын соёмбо дээд

сургуулийн зөвлөх Р.Батжаргал “Боловсролын салбарын стратеги төлөвлөлт” сэдэвт илтгэл, Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн Ц.Чанцалдулам Говь-Алтай аймгийн ЕБС-ийн “Хүүхэд хамгааллын суурь судалгааны үр дүн” сэдэвт илтгэл, мэргэжилтэн А.Ууганцэцэг “Сургалтын чанарын үзүүлэлтүүд” сэдэвт илтгэлүүдийг тус тус тавьж хэлэлцүүлээ. Мөн 2019-2020 оны хичээлийн жилийн зорилтын төслийг Боловсрол, соёл урлагийн газрын дарга Р.Батмөнх танилцуулж хэлэлцэн баталлаа. Мөн УИХ-ын гишүүн Ш.Раднаасэд сургууль, цэцэрлэгүүдэд тус бүр 10 ширхэг компьютер өгснийг сугалааны зарчмаар олгож гардууллаа.

НАЙМ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан сум, аймгийн төвийн өндөр настан 25, тахир дутуу 22. Нийт 47 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Шинээр хамруулсан: Сайн дурын даатгалд 10 хүн. Эрүүл мэндийн даатгалд 315 иргэнийн 13879.3 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Тэтгэмж тогтоолт, олголт: Хөдөлмөрийн чадвар түр алдсан 19 хүнд 3415,2 мянган төгрөг, Жирэмсэн, амаржсаны 25 хүнд 38550.1 мянган төгрөг, Оршуулга 12 хүнд 12.0 сая төгрөг тогтоож олгосон байна.

Ажилгүйдэл шинээр 7 хүнд 9112.1 мянган төгрөг. Олгосон нь 31 хүнд 9610.1 мянган төгрөг байна.

2019 оны 08 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 611 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаа ба 231 нь эмэгтэй байна. Тайлант сард аймгийн хэмжээнд 12 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авлаа.

Тайлант хугацаанд дараах ажлын байрын захиалга ирүүлсэн байна. Үүнд:

Баянтоорой багийн ерөнхий боловсролын сургуульд

- Нийгмийн ажилтан
- Нягтлан бодогч
- Бага ангийн багш
- Англи хэлний багш
- Химийн багш
- Хөгжмийн багш

Хаан банкны Говь-Алтай салбарын харъяа Цогт тооцооны төвд

- Теллер шалгаруулж авах ажлын байрны захиалга ирүүлснийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд хүргүүллээ.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдээс авах Солонгос хэлний түвшийн тогтоох шалгалтын бүртгэлийг тус газар 2019.08.07-08-ны өдрүүдэд зохион байгуулж, 17 хүн бүртгүүлснээс 5 эмэгтэй бүртгүүллээ.

ЕС. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Залуучуудын хөгжил оролцоог дэмжих, залуучуудын дуу хоолой санал бодлыг сонсох, тулгамдаж буй асуудлыг бодлого шийдвэрт тусгах, залуучуудын утга учиртай оролцоог хангах, урлаг, спортоор дамжуулан залуучуудад эерэг хандлагыг бий болгох зорилгоор аймгийн Засаг даргын ивээл дор "Төрөлх нутгаа хамтдаа хөгжүүлье" 1000 оюутан, залуусын урлаг, спортын их наадам 2019 оны 08 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд Алтай хотод зохион байгууллаа. Урлаг, спортын их наадам гар бөмбөг, үндэсний бөх, сур харваа, шатар теннис, ардын болон нийтийн дуу, эстрадын дуу, гоцлол бүжиг, уран уншлагын төрлүүдээр явагдаж 18 сум 2 тосгоны 870 залуучууд оролцож багийн нийлбэр дүнгээр

1-р байранд Жаргалант баг,

2-р байранд Чандмань сум

3-р байранд Оргил багийн тамирчид тус бүр шалгарлаа.

“Алтайн бахархал-2019” хурдан морины уралдаанд оролцож буй уралдаанч хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй байдалд хяналт тавьж ажиллалаа.

Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүмүүжлийн эерэг аргын талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 1-р цэцэрлэгийн 38 ажилтан албан хаагчдад сургалт зохион байгууллаа.

АРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Байгаль экологийн тэнцвэрийг хангах байгалийн муж бүс бүслүүрийн болон экосистем, ландшафт, биологийн төрөл зүйл ялангуяа дэлхийд ховордсон Монгол бөхөнгийн унаган нутгийг хамгаалах зорилгоор тус аймгийн Баян-Уул, Шарга, Дарив, Хөхморьт сумдын нутгийг хамран орших Хүйсийн говийн 854192 га газар нутгийг Байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах аймаг сумдын ИТХ-ын тогтоол гаргуулан БОАЖЯ-нд саналыг хүргүүллээ.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжигдэх аймгийн ерөнхий агнуурын ажлыг зохион байгуулахаар орон нутгийн өмчийн албатай хамтран худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд явуулж тендерт шалгарсан "Авралын эрэлд" ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүллээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас "Хандлагаа өөрчилъе " багц ажлын хүрээнд "Хоггүй, Цэвэрхэн Монгол" аяныг 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан удирдамж, мөн Алтайн хурд 2019 наадмыг зохион байгуулах ажлын хүрээнд Алтай хотын тохижилт үйлчилгээний газар, аймгийн нутгийн зөвлөлтэй хамтран морь барианы орчимд нийт 2.89 га талбайд нийтийн их цэвэрлэгээг зохион байгууллаа.

Мөн Швейцарийн элчин сайдын яамны Хамтын ажиллагааны газрын дэмжлэгтэйгээр БОАЖЯ-аас хийлгэж буй хүнд металл, мөнгөн ус, байгаль орчны бохирдлын судалгааны ажилд хамтран ажиллаж, Есөнбулаг сумын бохирдлын судалгааг хийж дууслаа. Энэхүү ажлын хүрээнд 22 газрын агаарт агуулагдаж байгаа мөнгөн усыг хэмжиж, хөрс болон уснаас дээж авсан бөгөөд, шинжилгээний ажил хийгдэж эхлээд байна.

Хот суурин газрын хатуу хог хаягдлын менежментийн төслийн хүрээнд шинээр байгуулах ландшафтийн хогийн цэгийн байршилыг тогтоож Барилга хот, байгуулалтын яаманд хүргүүллээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын санхүүжилтээр Алтай хотын гудамж талбай, гэр хороололд хогийн бункер хийх ажлын гүйцэтгэчээр "Бодонгийн ам" ХХК шалгарч гэрээ байгуулсан бөгөөд хогийн савыг хийж эхлээд байна.

Байгалийн нөөц баялгийг хууль бусаар ашиглах явдлыг таслан зогсоох, Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Ойн тухай, Байгалийн ургамлын тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр аймгийн хэмжээнд эргүүл, хяналт шалгалтын ажлыг Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран хийж байна.

Байгаль, орчин аялал жуулчлалын газар 8 дугаар сард Дарив сумын ЗДТГ, Ерөнхий боловсролын сургуульд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гарган тус тус хүргүүллээ.

АРВАН НЭГ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Төлөвлөгөөт 24 шалгалт, 1 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 18 албан шаардлага, 2 акт үйлдсэн байна.

Иргэн, аж ахуйн нэгжээс ирсэн өргөдөл хүсэлтийн дагуу 5 шалгалт хийж, 5.0 сая төгрөгийн арга хэмжээ авч ажиллалаа.

**Хоёр. Боловсрол, соёл, эрүүл мэнд, хүнсний чанар,
эрүүл ахуйн бодлогын хүрээнд:**

Хүнсний чанар аюулгүй байдлын талаар:

Халиун сумын 60 жил, "Алтайн хурд-2019" наадмуудын үеэр худалдаа үйлчилгээний 58, хоол үйлдвэрлэлийн 31 газарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан ажиллав.

МХЕГ-аас ирсэн үүрэг даалгаврын дагуу түргэн хоолны 5, хүнсний худалдааны 12 дэлгүүр, хоол үйлдвэрлэлийн 2 газарт урьдчилан сэргийлэх хяналт хийж үүрэг чиглэл өгч ажиллав.

Дулааны улиралтай холбоотой түргэн гэмтэж муудах хүнсний бүтээгдэхүүн авч хэрэглэхгүй байх талаар мэдээ мэдээллийг миний нутаг телевизэд өгөв.

Хүүхдийн эрүүл ахуйн хяналтаар:

Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдаж буй "Төрөлх нутгаа хамтдаа хөгжүүлэе" 1000 оюутан, залуучуудын урлаг, спортын их наадам зохион байгуулах ажлын хэсэгт орж, оролцогчдын өглөөний цай, үдийн хоол өгөх хоол үйлдвэрлэлийн газруудад хяналт хийж үүрэг чиглэл өгөв.

Мал эмнэлгийн хяналтаар:

Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу "Өгөөж-Алтай" хүнсний дэлгүүрт хамтарсан хяналт шалгалт хийж, илэрсэн дутагдлыг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч хууль эрх зүйн болон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Шарга, Есөнбулаг сумдын мал эмнэлгийн үйлчилгээний 3 нэгжийн малын эмч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Эмчилгээний чанар, халдвар судлалын хяналтаар:

Дүгнэн сувиллын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхэд №3.11.1, №3.11.2 кодтой хяналтын хуудсаар дунд эрсдэлтэй үнэлэгдэн илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын байцаагч нарын хамтарсан 13 заалттай хугацаатай албан шаардлага өгч, байгууллагын сургалт зохион байгуулав.

**Гурав. Байгаль орчин, уул уурхай, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй,
нийгмийн хамгаалал, үйлдвэрлэл үйлчилгээ,
дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:**

Байгаль орчны чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, авсан арга хэмжээ:

Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2019 оны 07-р сарын 23 –ны өдрийн аймгийн Засаг Даргын А/348 тоот захирамж гаргуулан эргүүл шалгалтыг зохион байгуулж, хууль бусаар агнасан 8 тарвагыг хураан авч, устган, 3.02сая төгрөгийн нөхөн төлбөр, торгуулийн арга хэмжээ авч ажиллав.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын байдалд шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан ажиллаж, "Зөрчлийн тухай" хуулийн дагуу арга хэмжээ тооцож ажиллав.

Газар, геодези зураг зүйн хяналтаар:

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, улсын байцаагчдын хамтарсан хугацаатай албан шаардлага хүргүүлж, 1 аж ахуйн нэгжид "Зөрчлийн тухай" хуулийн дагуу 100000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ тооцож ажиллав.

Байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу "Өөдрөг баян" ХХК-д төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж "Зөрчлийн тухай" хуулийн дагуу 5000000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ тооцож ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу барилгын материал, зам талбайн угсралт, шинэчлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа 2 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийв.

Хөдөлмөрийн хяналтаар:

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 1 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, улсын байцаагчдын хамтарсан хугацаатай албан шаардлага хүргүүлж, “Зөрчлийн тухай” хуулийн дагуу 500.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ тооцож ажиллав.

Морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангуулж ажиллах чиглэлээр улсын байцаагчийн зөвлөмж боловсруулан, аймаг сумдын морин спорт уяачдын холбоодод хүргүүлэн, өнгөрсөн хугацаанд аймаг орон нутгийн чанартай 2 наадам зохион байгуулагдсан бөгөөд, морь унаач хүүхдүүдийн хувцас хамгаалах хэрэгслээр хангагдсан, өмссөн байдалд холбогдох газруудтай хамтран хяналт хийж ажиллав.

Бүх сумдын ЗДТГ, Сургууль цэцэрлэгийн удирдлагуудад хүүхдийн тоглоомуудын аюулгүй байдлын хангуулах талаар албан бичиг хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллаж байна.

Барилга байгууламж (аймгийн хэмжээнд улсын болон ОНТ, төсөл хөтөлбөрөөр хийгдэж байгаа ажил):

Аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин баригдаж байгаа 13 барилга, байгууламжийн угсралтын ажил хийгдэж, гүйцэтгэл дунджаар 70%-тай байна. “Тайшир-Алтай” ус хангамжийн төслийн хүрээнд 14.0 сая еврогийн санхүүжилттэй 54.8 км урттай цэвэр усны шугамын барилга угсралтын ажил хийгдэхээс ажил 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 21 км шугамын барилга угсралтын ажил хийгдэж, гүйцэтгэл одоогийн байдлаар 40%-тай байна.

Автозамын үйл ажиллагааны талаар:

МХЕГ-ын 2019 оны 01/217 дугаартай удирдамжийн дагуу МХЕГ-ын холбогдох улсын байцаагчидтай хамтран улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Алтай хотын төвийн 3 км хатуу хучилттай замын угсралтын ажил, Говь-Алтай аймгийг дайран өнгөрч байгаа улсын чанартай авто замын засвар, арчлалтын ажлын чанар, 2017 онд ашиглалтад орсон Алтай-Ховд чиглэлийн 165 км авто замын ашиглалтын байдалд хамтарсан хяналт шалгалтыг гүйцэтгэж ажиллалаа.

Алтай хотын 4 км-ын үерийн далангийн барилга угсралтын ажил одоогийн байдлаар 50%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийгдэж байна.

Эрчим хүчний хяналтаар:

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 1 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж ажиллав.

Дөрөв. Нэгдсэн лаборатори:

Лабораторид 2 байгууллага, 3 аж ахуйн нэгжээс ирүүлсэн унд ахуйн усны 56 сорьцод 308 үзүүлэлтээр, хөрсний 1 сорьцод 1 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээ хийхэд 9 сорьц 9 үзүүлэлтээр/нянгийн тоо стандартаас 2-103 аар их/ стандартын шаардлага хангаагүй, шинжилгээний төлбөрийн төвлөрүүлэлт 1045.0 мянган байна.

Тав. Бургастайн хилийн Экспорт, импорт хил хорио цээрийн хяналтын хэлтэс

Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс:

Бургастайн орох чиглэлд: Монгол Улсын хилээр 1044 тээврийн хэрэгсэл орж ирснээс гадаад тээврийн хэрэгсэл 1033 байна. Зорчигчдын тухайд 1078 зорчигч орж ирснээс гадаадын 1051 иргэн байна.

Бургастайн гарах чиглэлд: Монгол Улсын хилээр 1046 тээврийн хэрэгсэл гарснаас гадаад тээврийн хэрэгсэл 1033 байна. Зорчигчдын тухайд 1059 иргэн гарснаас гадаадын иргэн 1034 байна.

Тус боомтоор 98273.5тн төмрийн хүдрийн баяжмал экспортлогдсон байна.

БУСАД:

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрийн дагуу Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд цаг уурын 6 өртөөнд 3 цаг тутамд, цаг уурын 14 харуулд 8 цаг тутамд дэлхийн цаг уурын байгууллагын хөтөлбөрийн дагуу агаарын даралт, агаар, хөрсний гадаргын температур, агаарын чийгшил, хур тунадас, салхи, цасан бүрхүүлийн тархац ба

зузаан (цас тогтсон үед), агаарын үзэгдэлд байнгын ажиглалт хийж байна. Мөн гадаргын ус судлалын 4, нуур судлалын 1 харуулд усны түвшин, урсгалын хурд, цас, мөсний үзэгдэл, үерийн түвшний ажиглалт хэмжилтийг хийсэн байна.

Алтай хотын агаарт агуулагдаж байгаа хүхэрлэг хий /SO₂/ болон азотын давхар исэл /NO₂/-ийн хэмжээг 08, 20 цагуудад тогтмол хэмжиж хэмжлийн үр дүнг 10 хоног тутам нэгтгэн УЦУОШТ-ийн цахим хуудсанд байршуулан ард иргэдэд мэдээлж ажилласан.

2019 оны 08 дугаар сарын 22-нд гадаргын усны дээжийг Тайшир сумын Завхан-Тайширын гол, Дэлгэр сумын Тайгам-нуураас авч Байгаль орчны шинжилгээний лабораторит химийн шинжилгээг хийсэн.

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх сургалтанд тус төвийн дарга Н.Алтантуяа, ЦУОТХэдтсийн дарга Т.Дэлгэрмаа нар 2019 оны 08 дугаар сарын 05-наас Улаанбаатар хотод ажилласан.

АРВАН ХОЁР. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ТАЛААР:

Баян-Уул сумын ЗДТГ “Малчдын зөвлөгөөн” зохион байгуулж, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Генетик нөөцийн тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Бэлчээр ашиглалтын хариуцлагажуулах журам, цаг агаарын урьдчилсан мэдээ, Нийгмийн даатгалын тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хуулиудаар мэдээлэл хийж, 200 малчин хамрагдлаа.

Бигэр сумын Сум дундын эмнэлгийг Монгол улсын хүний гавьяат эмч Л.Бордухын нэрэмжит болгох тухай аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр нэрэмжит болгох нээлтийн үйл ажиллагааг тус сумын ЗДТГ зохион байгууллаа.

Мөн Бигэр сумд Улсын төсвийн 1,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдах 100 хүүхдийн дотуур байрны барилгын ажлыг гүйцэтгэгч “Ашид гэгээн өргөө” ХХК 2019 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн ажлаа эхлүүлээ.

Бугат сумын ЗДТГ мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг ангиллыг зохион байгуулж, нийт 150 өрхийн хонь 8 өрхийн тэмээ малчин мал бүхий өрхүүдийн 2014-2018 оны малын судалгаа, генетик нөөцийн сумын төлөв байдлын судалгааг гаргалаа.

Дэлгэр сумд шинээр 320 хүүхдийн сургууль болон 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын шав тавигдаж, гүйцэтгэгчээр нь Шатат ХХК ажиллаж байна. Тус сумын нийт төрийн албан хаагчид, хувиараа бизнес эрхлэгч болон малчдыг хамруулан Гуулин, тайгам тосгоны нийт 64 иргэн Улсын их хурлын гишүүн Ш. Раднаасэд гишүүний дэмжлэгээр БНХАУ-ын Манжуур хотоор аяллаа.

Шарга сумын өвөлжөөлөлтийн бэлтгэл хангуулах төлөвлөгөөний дагуу сумын удирдлага, холбогдох мэргэжилтнүүд тус сумын хадлан бэлтгэлийн ажилтай танилцлаа. Жил бүр сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 50 тн өвсийг нөөцөлдөг ба энэ жил Ус-Алтай ХХК-тай гэрээ байгуулан сумын нөөцийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Цогт сум Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах төслийн санхүүжилтээр Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Ой судлалын сургуультай “Заган ойн тооллого”-ыг 08 сарын 01-05-ны хооронд Захуйн говьд 13 цэгийг сонгон авч заган ойн тооллого хийлээ.

Цөлжилтийн судалгаа 2019 оны 8-р сарын 23-ны өдөр Баян-Өндөр, Төгрөг, Баян-Улаан, Рашаант багуудын нутаг дэвсгэрт цөлжилтийн судалгааны ажлыг Доктор Н.Мандах, ЭША Д.Сүхдорж, Б.Сумъяадорж нартай хамтарч зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрлээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР